



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

2025 оны 4 дугаар сарын 28

Дугаар 1724

Улаанбаатар хот

Тамга, тэмдгийн хяналтын
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарг-ын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ (8448426)-ын Удирдах Зөвлөлийн дарга Б.Сумъяагийн гаргасан хүсэлтэд Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү.” гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ-нд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын бүртгэгч Л.Пүрэвжаргал 9023111325 хяналтын дугаар олгосон бүртгэл, Гүйцэтгэх удирдлагаар Ш.Баярхүү бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн мэдээлэл байхгүй байна.

2. Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ-ийн Удирдах Зөвлөлийн дарга Б.Сумъяагийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жигжиджав, Финанс төвд байршилтай, Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ-ийн тамга, тэмдгийн хяналтын 9023111325 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн №09 дугаартай удирдах зөвлөлийн тогтоол, түүнд Удирдах зөвлөлийн дарга Ц.Энхтайван, гишүүд Р.Даваа, Г.Батмөнх, Б.Сумъяа, Ш.Баярхүү нарын үсэгтэй, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн №08 дугаартай хүсэлт, түүнд удирдах зөвлөлийн дарга Б.Сумъяагийн гарын үсэгтэй хүсэлт, Өнөөдөр сонины 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №021(8076) дугаарт хүчингүйд тооцсон тухай зар зэрэг нотлох баримтаар Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ нь тамга, тэмдгийн хяналтын 9023111325 дугаартай тэмдгийг гэсэн болох нь нотлогдож байна.

1525030037

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Олон-Овоот гоулд ХХК-ийг 500 нэгжээр торгож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, торгож шийтгэл оногдуулсан тухай Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 0920392 дугаартай шийтгэлийн хуудас байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 8448426 регистрийн дугаартай Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ-д олгосон тамга, тэмдгийн хяналтын 9023111325 дугаарыг хүчингүй болгох.

2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Эрдэнэс таван толгой ахмадын хороо ГҮТББ-д мэдэгдэх.

3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



М.МӨНХГЭРЭЛ